



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг

Утас/Факс: 976-7054 3179

И-мэйл: govsumber@audit.gov.mn

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СҮМБЭР
СУМЫН ЭНХТУСДЭМ ЗГБХН
ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ О.ОДМАНДАХ
ТАНАА**

2024.02.22 № 13

танай _____ -ны № _____ -т

Татгалзсан дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Энхтусдэм ЗГБХН өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулга тайлангуудад аудит хийхээр байсан.

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Энхтусдэм ЗГБХН өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, тодруулга тайлангуудад дүгнэлт өгөхгүй. Дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн мэдэгдэхүйц нөлөөллийн улмаас санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөд хангалттай бөгөөд зохистой нотолгоо олж авах боломжгүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

Байгууллагын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн Эрүүл мэндийн газрын дарга, Сүмбэр сумын Засаг даргатай байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-ний биелэлт гэрээний шалгуур үзүүлэлтийн дагуу 89.7 хувиар дүгнэгдсэн байна. Гэвч тус үнэлгээний дүгнэлтийн зарим үзүүлэлтийг тулгахад 21.1 дэх "Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах" гэсэн үзүүлэлтийн хэрэгжилтэд авбал зохих 5 онооноос 5 оноогоор дүгнэж төсөв, санхүүгийн үйл ажиллагааг 100% гэж үнэлсэн байна.

Дээрх үнэлгээ нь бодит байдлаас зөрүүтэй байна. Мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасны дагуу удирдлагаас дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүйгээс тухайн байгууллагын санхүүгийн сахилга бат сул, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын тогтолцоо алдагдсан, хяналт байхгүй байна.

Дүгнэлт өгөхөөс татгалзсан үндэслэлүүд:

1. Энхтусдэм Өрхийн эрүүл мэндийн төвийн 2024.01.31-ний өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн аудит хийлгэхээс татгалзсан тайлбар
2. Аудитад шаардлагатай судалгааг гаргаж ирүүлээгүй, гаргаж өгөхөөс татгалзсан тайлбар
3. Тус байгууллага нь Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасан Монгол Улсын нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн хэсэг болох Эрүүл мэндийн даатгалын сангаас 848,691.3 мянган төгрөгийн санхүүжилт авч захиран зарцуулсан боловч Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулиудыг огт мөрдөөгүй, зөвхөн нөхөрлөлийн гишүүдийн

008020030

- шийдвэрийн дагуу санхүүжилтээр авсан орлогыг үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй захиран зарцуулсан байна.
4. Тухайн байгууллагын нийт цалингийн зардал нь 696,592.9 мянган төгрөг бөгөөд нөхөрлөлийн 10 гишүүн нь нийт цалингийн зардлын 51.9 хувь буюу нийт 361,779.1 мянган төгрөгийг цалин болон урамшуулал, ашиг хуваах хэлбэрээр авсан байна. Нөхөрлөлийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт нөхөрлөлийн гишүүд нөхөрлөлийн үүргийг оруулсан хөрөнгийн хэмжээгээр хариуцахаар зохицуулсан байхад нөхөрлөлийн гишүүд оруулсан хөрөнгийн хэмжээг хэтрүүлэн урамшуулал авсан нь Нөхөрлөлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийг зөрчсөн.
 5. 2022 онд 144,230.3 мянган төгрөгийн ашигтай ажилласан байхад ашгаас 2023 онд 159,799.7 мянган төгрөгийн урамшуулал ногдол ашиг хуваарилсан нь тайлант 2023 онд 122,629.1 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахад нөлөөлсөн байна. Нөхөрлөлийн хуулийн дагуу ашгаа хуваасан гэх боловч алдагдлаа хуваарилаагүй.
 6. Тайлант оны нийт цалингийн зардал нь 695,592.9 мянган төгрөг бөгөөд тус зардлын 23.0 хувь буюу 159,799.7 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Огноо	Гүйлгээний утга	Дүн
09-Feb	Гүйцэтгэлийн санхүүжилтийн нэмэгдэл	12,325.0
17-Feb	Ногдол ашиг	25,150.0
25-Jul	Үр дүнгийн урамшуулал	19,840.1
30-Nov	Үр дүнгийн урамшуулал	31,435.0
20-Dec	Гүйцэтгэлийн санхүүжилтийн нэмэгдэл	46,300.0
28-Dec	Засгийн газрын 52 дугаар хурлын тэмгэдлэлээр урамшуулал олгосон.	24,749.7
		159,799.7

Дээрх нийт олгосон урамшууллаас

- Тус байгууллага нь ЗГ-ын 12 дугаар сарын 28-нд өдрийн 52 дугаар хуралдааны тэмдэглэл нь Төсвийн тухай хуулийн 46.3.2-т заасны дагуу гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагаас бусад байгууллагын цалингийн сангийн хэмнэлтээс ажилтны ажлын үр дүнг нь харгалзан үзэж нэг сарын цалингийн 100 хүртэл хувиар тооцож урамшуулах нь зүйтэй гэж үзэж урамшуулал олгох тэмдэглэл гарсан. Гэвч тус байгууллага нь Төсвийн тухай хуулийг мөрдөн ажилладаггүй гэх боловч Засгийн газрын тогтоолын төсөл үндэслэн нөхөрлөлийн гишүүдийн хурлаар хамтын шийдвэр гаргаж, урамшуулалд хавтгайруулан 24,749.7 мянган төгрөгийн урамшуулал давхардуулан олгосон байна.
 - Байгууллагын удирдлага, нөхөрлөлийн гишүүд эрх мэдлээ хэтрүүлэн гучин хоёр ажилтанд 31,485.0 мянган төгрөгийн хууль журамд заагаагүй, эрх зүйн актаар зохицуулагдаагүй харьцаа хандлагын нэмэгдэл гэсэн нэртэй нэмэгдлийг сар бүр олгосон байна
7. Байгууллагын ажилчдын хүүхдүүдэд бэлэг, шинэ жилийн арга хэмжээнд сугалаа явуулж бэлэг өгөх зэргээр нийт 2,683.0 мянган төгрөгийн зардал гаргасан байна.
 8. Зургаан ажилтанд томилолттой байх хугацааны хоолны 125.0 мянган төгрөгийн зардлыг давхардуулан олгосон байна.
 9. Эм, эмнэлгийн хэрэгслийг тендер зарлаагүй 71,497.8 мянган төгрөгийн гэрээ байгуулан шууд худалдан авалт хийсэн байна.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нөхөрлөлийн тухай хуулийг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн аудитын толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА

